СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/170/-НА-СТА-ТШЗ


Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн:Пийк-Ом Аудит ХХК

Утас: 99862066 Цахим хаяг:peakomaudit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт…......................................................................3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан ......................................................................5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ...................................................6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ...............................9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................................................9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .................................................11
3.Аудитын тайлан ..............................................................................................12
3.1. Ерөнхий зүйл ................................................................................................12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ...............................................12
3.4. Материаллаг байдал......................................................................................13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .................................................................13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .......................................14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг........................................15
3.8 Аудитын гол асуудал......................................................................................16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ......16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....................................................16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт......................................................................16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .........................................................17
4.1 Залруулсан алдаа .........................................................................................17
4.2 Зөвлөмж .......................................................................................................18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....................................................18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| НА | Нотлох ажил |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| СЭА | Сэлэнгэ аймаг |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА 2022/170-НА-СТАТШ3

танай ______________-ны № ______________

СЭЛЭНГЭ АЙМГИЙН САЙХАН СУМЫН
4 ДҮГЭЭР ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.ЭНХТУНГАЛАГ ТАНАА

# АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

## Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.



018020332

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭНХТУЯА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,044,299.87** | **34,353,605.87** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **34,044,299.87** | **34,353,605.87** |
| **35100** | **Түүхий эд материал** | **61,300.00** | **-** |
| 35130 | Эм боох материал | 61,300.00 | - |
| **35400** | **Хангамжийн материал** | **33,982,999.87** | **34,353,605.87** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 802,500.00 | - |
| 35420 | Аж ахуйн материал | 11,827,188.60 | 13,557,688.60 |
| 35450 | Барилгын засварын материал | 829,200.00 | - |
| 35460 | Хүнсний материал | - | 271,806.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 20,524,111.27 | 20,524,111.27 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **296,056,759.45** | **284,331,640.35** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **296,056,759.45** | **284,331,640.35** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **286,534,759.41** | **275,059,640.27** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 287,519,505.85 | 287,519,505.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (28,123,294.74) | (42,047,416.26) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 29,321,365.00 | 36,521,365.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (10,656,041.68) | (14,861,505.48) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,017,917.59 | 15,163,372.59 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,282,040.05) | (12,073,028.91) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 10,902,417.00 | 12,402,417.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (7,165,069.56) | (7,565,069.52) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **9,522,000.04** | **9,272,000.08** |
| 39301 | Програм хангамж | 1,450,000.00 | 1,450,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (449,999.96) | (699,999.92) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,522,000.00 | 8,522,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **330,101,059.32** | **318,685,246.22** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **6,891,734.00** | **7,868,273.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **6,891,734.00** | **7,868,273.00** |
| **41300** | **Өглөг** | **6,891,734.00** | **7,868,273.00** |
| **41360** | **Бусад өглөг** | **6,891,734.00** | **7,868,273.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 6,891,734.00 | 7,868,273.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **323,209,325.32** | **310,816,973.22** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **323,209,325.32** | **310,816,973.22** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 111,097,511.30 | 111,097,511.30 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **(85,836,145.27)** | **(98,228,497.37)** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (115,157,472.33) | (85,836,145.27) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 29,321,327.06 | (12,392,352.10) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 297,947,959.29 | 297,947,959.29 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **330,101,059.32** | **318,685,246.22** |

## 2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **428,192,809.77** | **378,893,846.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **26,602,809.77** | **3,085,846.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **26,602,809.77** | **3,085,846.00** |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 8,955,576.00 | 1,645,455.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 17,647,233.77 | 1,440,391.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **401,590,000.00** | **375,808,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **357,023,500.00** | **342,358,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 357,023,500.00 | 342,358,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **189,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 189,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **44,566,500.00** | **33,260,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,566,500.00 | 33,260,200.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **398,871,482.71** | **391,286,198.10** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **398,871,482.71** | **391,286,198.10** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **370,224,660.71** | **380,968,285.75** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **268,412,561.00** | **271,271,372.65** |
| 210101 | Үндсэн цалин | 172,167,060.17 | 199,653,740.65 |
| 210102 | Нэмэгдэл | 77,187,600.83 | 51,936,616.00 |
| 210104 | Урамшуулал | 19,057,900.00 | 19,681,016.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,532,597.00** | **35,910,050.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 22,802,171.00 | 25,046,572.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,682,607.00 | 2,715,868.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,146,085.00 | 2,172,695.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 536,521.00 | 543,177.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,365,213.00 | 5,431,738.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **31,422,536.00** | **33,713,839.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,135,914.00 | 3,527,583.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,970,254.00 | 27,153,336.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,316,368.00 | 3,032,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,257,924.00** | **3,404,791.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 229,800.00 | 121,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 277,500.00 | 220,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 550,000.00 | 550,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 288,000.00 | 551,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| zfgcn210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,798,100.00 | 1,961,591.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,114,524.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | **8,096,790.00** | **10,152,159.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 57,800.00 | 497,300.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,038,990.00 | 9,654,859.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **880,600.00** | **3,689,500.00** |
| 210604 | Урсгал засвар | 880,600.00 | 3,689,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **292,600.00** | **88,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 292,600.00 | 88,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **472,700.00** | **1,048,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 148,700.00 | 400,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **19,856,352.71** | **21,690,574.10** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,333,200.00 | 1,120,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,523,152.71 | 20,570,574.10 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,646,822.00** | **10,317,912.35** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **400,000.00** | **-** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | - |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **28,246,822.00** | **10,317,912.35** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,246,822.00 | 10,317,912.35 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **29,321,327.06** | **(12,392,352.10)** |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **29,321,327.06** | **(12,392,352.10)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **401,590,000.00** | **375,808,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **401,590,000.00** | **375,808,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **357,023,500.00** | **342,358,800.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 357,023,500.00 | 342,358,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **-** | **189,000.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 189,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **44,566,500.00** | **33,260,200.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,566,500.00 | 33,260,200.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **390,040,000.00** | **368,608,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **390,040,000.00** | **368,608,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **361,393,178.00** | **357,890,087.65** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **268,412,561.00** | **271,271,372.65** |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 172,167,060.17 | 199,653,740.65 |
| 210102 | Нэмэгдэл | 77,187,600.83 | 51,936,616.00 |
| 210104 | Урамшуулал | 19,057,900.00 | 19,681,016.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **33,532,597.00** | **35,910,050.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,691,963.00 | 25,046,572.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,460,159.00 | 2,715,868.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,968,127.00 | 2,172,695.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 492,031.00 | 543,177.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,920,317.00 | 5,431,738.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **43,737,300.00** | **32,737,300.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,135,914.00 | 3,527,583.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,285,018.00 | 26,176,797.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,316,368.00 | 3,032,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,420,800.00** | **2,403,200.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 230,100.00 | 121,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 277,500.00 | 220,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 550,000.00 | 550,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,200,000.00 | 551,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,163,200.00 | 960,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **7,481,920.00** | **10,851,865.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 284,100.00 | 363,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,589,320.00 | 9,926,665.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 608,500.00 | 561,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **1,709,800.00** | **2,860,300.00** |
| 210604 | Урсгал засвар | 1,709,800.00 | 2,860,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **292,600.00** | **88,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 292,600.00 | 88,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **472,700.00** | **648,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 148,700.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 648,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,332,900.00** | **1,120,000.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,332,900.00 | 1,120,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,646,822.00** | **10,717,912.35** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **400,000.00** | **400,000.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **28,246,822.00** | **10,317,912.35** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 28,246,822.00 | 10,317,912.35 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **11,550,000.00** | **7,200,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **11,550,000.00** | **7,200,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **11,550,000.00** | **7,200,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **11,550,000.00** | **7,200,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 11,550,000.00 | 7,200,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(11,550,000.00)** | **(7,200,000.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | 0.00 | 0.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 0.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | 0.00 | 0.00 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 0.00 | 0.00 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 100 | Тохируулгын орлого, зарлагын зөрүү | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(115,157,472.33)** | **293,887,998.26** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(115,157,472.33)** | **293,887,998.26** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **-** | **-** | **-** | **-** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **29,321,327.06** | **29,321,327.06** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(85,836,145.27)** | **323,209,325.32** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(85,836,145.27)** | **323,209,325.32** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(85,836,145.27)** | **323,209,325.32** |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (12,392,352.10) | (12,392,352.10) |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **111,097,511.30** | **297,947,959.29** | **(98,228,497.37)** | **310,816,973.22** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **375,619,000.00** | **365,301,087.65** | **10,317,912.35** | **97.25** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **375,619,000.00** | **365,301,087.65** | **10,317,912.35** | **97.25** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **375,219,000.00** | **364,901,087.65** | **10,317,912.35** | **97.25** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **274,983,700.00** | **271,271,372.65** | **3,712,327.35** | **98.65** |
| 210101 | Үндсэн цалин | 205,800,800.00 | 199,653,740.65 | 6,147,059.35 | **97.01** |
| 210102 | Нэмэгдэл | 49,500,000.00 | 51,936,616.00 | (2,436,616.00) | **104.92** |
| 210104 | Урамшуулал | 19,682,900.00 | 19,681,016.00 | 1,884.00 | **99.99** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **35,941,100.00** | **35,910,050.00** | **31,050.00** | **99.91** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 24,941,700.00 | 25,046,572.00 | (104,872.00) | **100.42** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,749,800.00 | 2,715,868.00 | 33,932.00 | **98.77** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,199,900.00 | 2,172,695.00 | 27,205.00 | **98.76** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 550,000.00 | 543,177.00 | 6,823.00 | **98.76** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,499,700.00 | 5,431,738.00 | 67,962.00 | **98.76** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **32,737,300.00** | **32,737,300.00** | - | **100.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,900,000.00 | 3,527,583.00 | 3,372,417.00 | **51.12** |
| 210302 | Түлш, халаалт | 22,520,900.00 | 26,176,797.00 | (3,655,897.00) | **116.23** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,316,400.00 | 3,032,920.00 | 283,480.00 | **91.45** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,214,200.00** | **2,214,200.00** | **-** | **100.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 183,700.00 | 121,000.00 | 62,700.00 | **65.87** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 220,500.00 | 220,500.00 | **-** | **100.00** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 550,000.00 | 550,000.00 | **-** | **100.00** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 300,000.00 | 362,700.00 | (62,700.00) | **120.90** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 960,000.00 | 960,000.00 | - | 100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **17,102,400.00** | **10,851,865.00** | **6,250,535.00** | **63.45** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 363,600.00 | 363,600.00 | - | **100.00** |
| 210502 | Хоол, хүнс | 16,177,200.00 | 9,926,665.00 | 6,250,535.00 | **61.36** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 561,600.00 | 561,600.00 | 10.00 | **100.00** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,060,300.00** | **10,060,300.00** | **-** | **100.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,200,000.00 | 7,200,000.00 | **-** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 2,860,300.00 | 2,860,300.00 | **-** | **100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **88,000.00** | **88,000.00** | **-** | **100.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 88,000.00 | 88,000.00 | **-** | **100.00** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **972,000.00** | **648,000.00** | **324,000.00** | **66.67** |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 972,000.00 | 648,000.00 | 324,000.00 | **66.67** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,120,000.00** | **1,120,000.00** | **-** | **100.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,120,000.00 | 1,120,000.00 | **-** | **100.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **400,000.00** | **400,000.00** | **-** | **100.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **400,000.00** | **400,000.00** | **-** | **100.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 400,000.00 | **-** | **100.00** |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **375,619,000.00** | **375,619,000.00** | **-** | **100.00** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **342,358,800.00** | **342,358,800.00** | **-** | **100.00** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 342,358,800.00 | 342,358,800.00 | **-** | **100.00** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **33,260,200.00** | **33,260,200.00** | **-** | **100.00** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 33,260,200.00 | 33,260,200.00 | **-** | **100.00** |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **103,051.00** | **154.00** | **102,897.00** | **0.15** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **-** | **100.00** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **25.00** | **25.00** | **-** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 9.00 | **-** | **100.00** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 620003 | Үйлчлэх ажилтан | 15.00 | 15.00 | **-** | **100.00** |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **103,000.00** | **103.00** | **102,897.00** | **0.10** |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **103,000.00** | **103.00** | **102,897.00** | **0.10** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 103,000.00 | 103.00 | **102,897.00** | **0.10** |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **25.00** | **25.00** | **-** | **100.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 25.00 | 25.00 | **-** | **100.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **189,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **-** | **189,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 189,000.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 189,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 189,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 189,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 189,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 189,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн */цаашид Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг/* 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өгсөн бараа материалын бүртгэл хөтлөлт, төлбөрийн цахим баримттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ийн аудитор А.Батболд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг нь тайлант онд *“Хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад бүх талуудтай хамтран ажиллая”* гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Сургуулийн өмнөх насны боловсрол олгох.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,

- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэж байна.

Тус цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

### 3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 398,871.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,988.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 2,792.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 6,319.2 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

*Хүснэгт 1:* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|

| Б | 1 | 2 | 3=2-1 |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 34,044.30 | 34,353.60 | 309.30 |
| Үндсэн хөрөнгө | 296,056.80 | 289,428.30 | (6,628.50) |
| Нийт хөрөнгө | 330,101.10 | 323,781.90 | (6,319.20) |
| Өр төлбөр | 6,891.70 | 7,868.20 | 976.50 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 323,209.30 | 315,913.60 | (7,295.70) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 330,101.00 | 323,781.80 | (6,319.20) |

Бараа материалын дансны үлдэгдэл 34,353.6 мянган төгрөг болж 309.3 мянган төгрөгөөр өссөн нь 271.8 мянган төгрөгийн хүнсний материалын зарцуулагдаагүй үлдэгдлээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл */анхны өртгөөр/* 361,578.6 мянган төгрөг болж өмнөх оноос 7,345.4 мянган төгрөгөөр өссөн нь 7,200.0 мянган төгрөгөөр проектор, дэлгэц, хөлдөөгч, битүү чанагч, хайруулын таваг, принтер зэрэг хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 145.4 мянган төгрөгийн халуун хэмжигч, Бум-Эрдэнэ ХХК-аас 1,500.0 мянган төгрөгийн гэрлэн хаяг тус тус хандиваар авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 315,913.6 мянган төгрөг болж 7,295.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 378,893.8 мянган төгрөг болж өмнөх оноос 49,299.0 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан байна. Энэ нь “Ковид-19” цар тахлын улмаас тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого 14,664.7 мянган төгрөгөөр, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 11,306.3 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого 25,517 мянган төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 391,286.2 мянган төгрөг болж өмнөх оноос 7,585.2 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан нь хангамж, бараа материалын зардал 3,853.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 415,241.3 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 39,622.3 мянган төгрөгөөр бууруулж, 375,619.0 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр **375,619.0** мянган төгрөгийн төсөв баталснаас 342,358.8 мянган төгрөгийг улсын төсвөөс */тусгай зориулалтын шилжүүлгээр/*, 33,260.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 342,358.8 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 33,260.2 мянган төгрөг, нийт 375,619.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 365,301.1 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 10,317.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **365,301.0** мянган төгрөг буюу 97.3 хувьтай тайлагнагдсан нь цалин урамшууллын зардлыг 3,712.3 мянган төгрөг, норматив зардлыг 6,250.5 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 324.0 мянган төгрөгийн нийт 10,286.8 мянган төгрөгийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд БСГ-аас ариутгалын санхүүжилтэд 189.0 мянган төгрөг олгосныг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

**3.7.1** Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмын 3 дахь “Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно.” гэсэн заалт болон Боловсрол шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35,А/10/9 тушаалын 10 дахь “цэцэрлэг, сургуулийн түвшинд амжилт гаргасан 10%, сум, дүүргийн түвшинд амжилт гаргасан 15%, аймаг, нийслэлийн түвшинд амжилт гаргасан 20%, улс, бүс, олон улсын түвшинд амжилт гаргасан 25%” гэж заасан боловч цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, багш, туслах багшийн ажлын үр дүнг нь шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, дүгнэлгүйгээр ур чадварын нэмэгдлийг сард 10-25 хувиар тооцож олгож байна. Цаашид ажлын үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж дүгнэн олгож байх нь зүйтэй юм.

**3.7.2** БШУ-ны сайд болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн А/292, А/525 дугаар хамтарсан "Түр журам журам батлах тухай" тушаалын нэгдүгээр хавсралт "Короновируст халдварын үед цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаагаа зохион байгуулахад мөрдөх түр журам"-ын дагуу сургалтын үйл ажиллагааг танхим болон танхимын бус сургалтад шилжүүлсэн байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэгт 375,619.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 365,301.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 2.7 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: *".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах"* гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 195.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 төлбөрийн акт, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой 1 зөвлөмж өгснөөс төлбөрийн актыг барагдуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

| **Үзүүлэлт** | **Өмнөх оны илрүүлэлт** | | **Биелэлт** | | **Хэрэгжилтийн хувь** |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | |
| Төлбөрийн акт | 1 | 195.0 | 1 | 195.0 | 100 |
| Зөвлөмж | 1 | | 1 | | 100 |
| **Нийт дүн** | **2** | **195.0** | **2** | **195.0** | **100.0** |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 83,123.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.096.7 мянган төгрөгийн 1 зөрчлийг аудитын явцад залруулж, 78,026.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийг 5,096.7 мянган төгрөгөөр дутуу байгуулсныг залруулан бүртгэв.

### 4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав.

***1. Анхан шатны баримт хөтлөлт, бүрдүүлэлттэй холбоотой асуудал***

***1.1 Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд***

*1.1.* *<u>Илрүүлэлт:</u>* Тайлант онд 76,324.6 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

*1.2* *<u>Өгсөн зөвлөмж</u>:* Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д "*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй"* гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь "*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу*

*бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ”* гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

2. ***Бараа материалын тайлантай холбоотой асуудал***

2.1. *Илрүүлэлт:* Бараа материалын тайлангаар бичиг хэргийн материалын дансанд 1,566.5 мянган төгрөгийн хангамжийн материалыг бүртгэсэн, 70.5 мянган төгрөгийн шатахуун, 65.0 мянган төгрөгийн бичгийн хорыг бараа материалд орлого аваагүй буюу тооцооны дансаар дамжуулалгүйгээр шууд зардалд тус тус бүртгэсэн байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:* Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д “*Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө*”, 13.4-д “*Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан **хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг** анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.*”, гэж заасантай нийцээгүй ба "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул бараа материалын ангиллыг зөв бүртгэх.

***3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал***:

*3.1 Илрүүлэлт:* Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

*3.2 Өгсөн зөвлөмж*: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Сэлэнгэ аймгийн Сайхан сумын 4 дүгээр цэцэрлэг | 4 | 83,123.3 | 1 | 5,096.7 | | | | | 3 | 78,026.6 |